

АРИЛЖААНЫ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2025 оны 05 сарын 09-ны өдөр

Арилжааны тухай хуульд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Арилжааны тухай хуулийн төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
3.1. Арилжааны эрх зүйн харилцаанд Иргэний хуульд заасан зарчмыг хөндөхгүйгээр дараах зарчмыг баримтална: 3.1.1. арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах; 3.1.2. гадаад нөхцөл байдалд үнэнч шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах; 3.1.3. арилжаа эрхлэгч нь үүргээ биелүүлэхдээ мэргэшсэн, хариуцлагатай хандах; 3.1.4. арилжааны үйл ажиллагааны хялбар, шуурхай байдлыг хангах;	Нэмэх: 3.1.5. нийтэд нээлттэй байх 3.1.6. хэлбэржсэн байх	3.1.5. нийтэд нээлттэй байх Арилжааны эрх зүй нь арилжааны үйл ажиллагаатай холбоотой тодорхой мэдээлэл бүртгэх, түүний зарим хэсгийг нийтэд нээлттэй мэдээлэх зэргээр арилжааны харилцаанд оролцож байгаа нөгөө талд хохирол учрахаас сэргийлдэг. Түүнчлэн гадаад илэрхийлэл, хэлбэр нь бодит агуулгатай нийцэхгүй тохиолдолд гадаад хэлбэрт итгэсэн этгээдийг хамгаалах зохицуулалтыг тусгай хуулиудад нарийвчлан тусгадаг. Өөрөөр хэлбэл төлөөлөх бүрэн эрхгүй байсныг мэдээгүй болон мэдэх боломжгүй байсны улмаас хэлцэл хийсэн шударга нөгөө талыг хамгаалах ёстой гэж үздэг. Энэ хүрээнд арилжаа эрхлэгчийн улсын бүртгэл нь томоохон чиг үүрэг гүйцэтгэнэ ¹ . Мөн энэхүү зарчмыг тус хуулийн төслийн 3.2 дахь хэсгийн 3.2.5 дахь заалтад “арилжаа эрхлэгчийн зарим мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байлгах, хэлцэл хийх үед олон нийтэд нээлттэй байсан арилжааны бүртгэлийн мэдээллийг

¹ Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (2022) 25 тал

		үнэн зөв гэж тооцох” хэмээн зарчмыг хэрэгжүүлэхээр заасан байна. Иймд энэхүү зарчмыг заах нь зүйтэй гэсэн саналтай байна. 3.1.6. хэлбэржсэн байх Арилжаа нь тодорхойлох боломжгүй олон тооны этгээдтэй, их хэмжээгээр хийгдэх тул тухайн харилцааг хялбар байдлаар зохион байгуулах шаардлага үүсдэг. Улмаар арилжаа эрхлэгч нь тодорхойлох боломжгүй олон тооны этгээдтэй гэрээний харилцаанд орох тохиолдолд гэрээний стандарт нөхцөлийг ашиглах бөгөөд энэ нь хэлбэржсэн байдлын тод илрэл юм. Гэрээний стандарт нөхцөл нь арилжааны харилцаа хялбар зохион байгуулахад томоохон үүрэг гүйцэтгэхээс гадна маргаанаас урьдчилан сэргийлэх, харилцагчид тэгш хандах зэрэг давуу талыг үүсгэдэг². Мөн энэхүү зарчим нь арилжааны эрх зүйд маш чухал үүрэг гүйцэтгэдэг “Арилжааны үйл ажиллагааны хялбар, шуурхай байдлыг хангах” зарчим хангагдах нөхцөлийг бүрдүүлдэг байна.
--	--	--

---oOo---

² Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл, Арилжааны эрх зүй, (2022) 24 тал